



ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРГАЛТЫН ТАЙЛАН

REF No. C003 – “Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл”

Монгол улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
2017 оны 10 сарын 30 өдөр



Захиалагчийн лого –
илгээнэ уу

Баримт бичгийн товъёог

| Хувилбар | Тайлан | Огноо |
|-------------|---------------------------------------|------------|
| 30072017 v1 | Эко-аялал жуулчлалын сургалтын тайлан | 30/10/2017 |

Талархал

Энэхүү тайланг TRC Tourism Pty Ltd болон Нэмүүн Трэвэл энд Консалтинг Сервисес ХХК бэлдэв.

Анхааруулга

Энэхүү баримт бичигт туссан аливаа төлөөлөл, мэдэгдэл, зөвлөгөө, санал нь сайн санааны үүднээс бичигдсэн бөгөөд TRC Tourism нь энэ бичиг баримт дахь аливаа төлөөлөл, мэдэгдэл, саналын дагуу үйлдэл, эс үйлдэл хийсэн этгээдэд учирсан буюу учирч болох хохирол, алдагдлыг хариуцахгүй болно .

1 ҮНДЭСЛЭЛ

1.1 Танилцуулга

Тус баримт бичиг нь 2017 оны 10 сарын 17-21 хооронд Хатгал тогсонд хийгдсэн Эко-аялал жуулчлалын сургалтын тайлан юм. Сургалтын хөтөлбөрийг Хөвсгөл нуурын БЦГ дахь Хатгал тосгон, Ханх сумдын нутгийн иргэдийн амжиргааг эко-аялал жуулчлалаар дамжуулан дээшлүүлэх зорилгоор тусгайлан бэлдсэн бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд 2017 оны 7 сард тус багийнхан Хөвсгөл нуурын БЦГ ажиллаж, холбогдох сонирхлын бүлгүүдийн төлөөлөлтэй уулзан тэдгээрийн саналуудыг тусгасан юм.

1.2 Сургалтын хөтөлбөр

| Өдөр | Хөтөлбөр | Сургагч багш | Оролцогчдын тоо |
|----------------------------|---|---|-----------------|
| Даваа, Мягмар | Хатгалруу аялж, сургалтын танхим, техник хэрэгслийг шалгасан | Жанет МакКэй, Дэвид Бамфорд, Ё. Бадрал, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан | |
| Лхагва 10/18 0900-12.30 | Орон нутгийн АЖ үзэл баримтлал, алсын хараа | Жанет МакКэй, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр | 28 |
| Лхагва 10/18 0900-12.30 | Жуулчны урсгал, түүний менежмент-үндсэн зарчмууд хэрэгжилт | Дэвид Бамфорд, Ё. Бадрал | 24 |
| Лхагва 10/18 2-5.30 | Аялал жуулчлалын бүтээгдхүүн бий болгох | Дэвид Бамфорд, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр | 28 |
| Лхагва 10/18 2-5.30 | ТХГН дахь аялал жуулчлал, байгальд ээлтэй аяллын төрлүүд | Жанет МакКэй, Ё. Бадрал, Х. Түмэндэлгэр | 25 |
| Пүрэв 10/19 0900-12.30 | Гар урлалын бүтээгдхүүний хөгжил, Аялал жуулчлал | Б. Шатарсайхан, Жанет МакКэй, Ё. Бадрал, Х. Түмэндэлгэр | 30 |
| Пүрэв 10/19 2-5.30 | Гар урлал, бүтээгдхүүний сав баглаа боодол зах зээлд нийлүүлэлт | Б. Шатарсайхан | 30 |
| Пүрэв 10/19 0900-5.00 | Аяллын хөтөч тайлбарлагчийн ур чадвар | Дэвид Бамфорд, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр | 40 |
| Баасан 10/20 0900-12.30 | Аялал жуулчлалын үйлчилгээний харилцааны соёл, зочлох үйлчилгээ | Жанет МакКэй, Ё. Бадрал, Х. Түмэндэлгэр | 32 |
| Баасан 10/20 0900-12.30 | Жижиг бизнесийн удирдлага, санхүүжилт | Дэвид Бамфорд, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр | 18 |
| Баасан 10/20 2-5.30 | Аялал жуулчлалын үйлчилгээний харилцааны соёл, зочлох үйлчилгээ | Дэвид Бамфорд, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр | 18 |
| Баасан 10/20 2-5.30 | Жижиг бизнесийн удирдлага, санхүүжилт | Жанет МакКэй, Ё. Бадрал | 32 |
| Бямба 10/21 | Гар урлалын | Б. Шатарсайхан, Жанет | 21 |

| | | | |
|-----------------------|--|---|--|
| 0900 – 1.30 | бүтээгдхүүний хөгжил, сав баглаа боодол зах зээлд нийлүүлэлт | МакКэй, Ё. Бадрал, Х. Түмэндэлгэр | |
| Бямба 10/21 2-4pm | Аялал жуулчлал эрхэлдэг нутгийн иргэдийн уулзалт | Жанет МакКэй, Дэвид Бамфорд, Ё. Бадрал, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан | |
| Ням-Даваа 10/22-23 | Улаанбаатар буцах | Жанет МакКэй, Дэвид Бамфорд, Ё. Бадрал, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан | |

1.2.1 Талархал

REF No. C003 – “Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл”-ийн ажилтан Д. Баярмагнай хээрийн томилолтонд хамт явж сургалтын ажилд туслалцсанд талархал илэрхийлэе. Мөн Хатгал дахь төслийн хамт олонд баярласнаа илэрхийлж байна.

Хатгал сумын засаг дарга Б. Ганбаатар болон ХНБЦГ-ын захирал Д.Батдэлгэр нар сургалтын багийнхантай уулзаж ярилцаж их тус дэм үзүүлснийг дурдаж байна.



2 Сургалтын үнэлгээ

Хөтөлбөр

Бидний үзэж байгаагаар тус сургалт нь их амжилттай болж өнгөрлөө. Сургалт болгоны эцсээр оролцогч нараар бөглүүлсэн санал сэтгэгдлийн хуудсаар энэ дүгнэлт батлагдаж байна. (Санал сэтгэгдэл, үнэлгээний хураангуйг Хавсралт №1 харна уу)

Олон улсын болон үндэсний багийн мэдлэг, ур чадвар нь хавсраад сургалтын бүтэц, хэрэглэгдсэн жишээнүүдийг их сонирхолтой болгож, суралцагчдад хүрч чадсан. Олон улсын жишээнээс шинэ санаа авах, өөрийнхөө бодлыг батлагаажулахад илүү хэрэгтэй байсан бол орон нутгийн жишээ, тэргүүн туршлага нь газар хөрсөн дээр бууцтай бөгөөд оролцогч нарт илүү их урам зориг өгч байсан.

Цаашдын сургалтанд аливаа видео, мултимедиа ашиглаж болох боловч техникийн нөхцөл байдал нь илүү байх шаардлагатай – WiFi, өсгөгч, микрофон гэх мэт.

Тус багийн үзэж байгаагаар зарим сургалтуудыг танхимын бус орчинд хийвэл илүү үр дүнтэй болох магадлалтай. Жишээ нь Аялал жуулчлалын үйлчилгээний харилцааны соёл, зочлох үйлчилгээ гэсэн сургалтыг аль нэгэн гэр буудал юм уу бааз дээр хийвэл, оролцогч нарын хувьд практик дээр өөрийн биеээр оролцож хийснээр илүү өгөөжтэй байх болно. Мөн зарим гэр буудлууд өөрийн үйл ажиллагаагаа бусаддаа сурталчилах боломж нээгдэнэ.

Гар урлалын чиглэлээр ажилласан үндэсний мэрэгжилтэн Б. Шатарсайхан нь тус сургалтанд их хувь нэмэртэй байсан бөгөөд олон чиглэлээр уран бүтээлээ туурвидаг нь олон төрлийн жишээ, санаанууд гаргахад нь тус болж хүнд хүрсэн бөгөөд практик дасгалууд нь их өндөр үнэлэмж авсан байна.

Хичээлүүдээ төлөвлөсөн цагтаа багтааж хийх нь багийн хувьд хамгийн хүндрэлтэй байсан. Сургалтууд нь синхрон орчуулгатай явж байсан бөгөөд нэг сургалтанд орхоор төлөвлөж байсан хүний тоо ихэссэнээс болж хүн болгонд хүрж ажиллахад хүндрэлтэй байсан. Оролцогчид их идэвхтэй байсан бөгөөд сургалтууд ихэнхдээ харилцан ярилцах хэлбэрээр явагдсан.

Цаашилбал оролцогч нарын мэдлэгийн түвшин харьцангуй өөр байсан. Зарим нь тухайн чиглэлээр олон жил үйл ажиллагаа явуулж байхад нөгөөд нь бизнесээ зөвхөн эхлэж байгаа буюу эхлэх сонирхолтой хүмүүс байж таарсан. Энэ асуудлыг шийдхийн тулд оролцогч нарыг эрт бүртгэн, дунд нь судлагаа явуулж хуваагаад тус болгоны түвшинд тааруулсан сургалт явуулж болох юм. Гэхдээ өнгөрсөн сургалтын явцад илүү туршлагажсан хүмүүс нь нөгөө хүмүүстэй туршлагаа хуваалцаж, багш нартай ярилцах замаар явсан нь бүх оролцогчдод сонирхолтой байж чадсан.

Дээрх асуудлууд дээр үндэслэн дараа дараагийн сургалтанд тодорхой өөрчлөлтүүдийг оруулхаар төлөвлөж байна.

Сургалтын үр дүн

Нутгийн иргэдийг чадавхжуулах сургалтын сацуу оролцогч нартай хийсэн уулзалтуудын явцад дараахь саналууд гарсныг тоймлон оруулсныг болгооно уу:

Ёс зүйн дүрмүүд – эдгээрүүдийг олон нийтийн хүртээл болгохын тулд илүү ойлгомжтой бөгөөд хураангуй байдлаар гаргах нь чухал. Хөвсгөл нуурын БЦГ нутгийн нэвтрэх цэгээр орж ирж буй хүн болгонд хүргэх арга замуудыг олох нь чухал. Нэгэн жишээг хавсаргав (Хавсралт №2).

Байгаль орчин хамгаалал

- Хуванцар хог хаягдлын асуудлыг шийдхийн тулд сав баглаа боодлын бодлого боловсруулах
- Ариун цэврийн байгууламжийн тогтолцоог төгс шийдэх

Гар урлал буюу бэлэг дурсгалын бүтээгдэхүүний борлуулалт – оновчтой бөгөөд шудрага өрсөлдөөнийг дэмжсэн өөрчлөлтүүдийг хийж БЦГ захиргааны харъя Мэдээллийн төв, нэвтрэх цэгүүдээр дамжуулан борлуулах гэх мэт.

Жуулчны урсгалын менежмент – ХНБЦГ захиргааны зүгээс ирэх жуулчны улирлыг угтан нарийвчилсан ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байгаа хэдий ч зуны улирлын хэт ачааллын үеийн жуулчны урсгалын менежментийг нэг мөсөн, тууштайгаар шийдхийн тулд Жуулчны Урсгалын Менежментийн дэд хөтөлбөрийг боловсруулах нь чухал гэж үзэж байна. Ингэснээр БЦГ менежментийн төлөвлөгөө ч илүү төгс, чанартай болно.

Жуулчны тоог нэмэгдүүлэх – зуны оргил үед ирж буй жуулчны ачаалалтай холбоотой асуудлууд хурцаар тавигдаж, дэд бүтэц ачааллаа даахгүй байгаа талаар талууд нэг бус удаа ярилцав. АХБ зээлийн төсөл хэрэгжсэнээр тус ачаалал ихсэх тул одооноос Аялал Жуулчлалын менежментийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх нь нэн чухал болоод байна.

Орон нутгийн Аялал Жуулчлалын Холбоо – сургалтын турш хамтын бүтээгдхүүн бий болгох, хамтын ажиллагааны ач тусын талаар удаа дараа ярилцсан билээ. Сургалтын сүүлийн өдөр орон нутгийн аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөлөл цугларан Хатгалын Аялал жуулчлал эрхлэгчдийн Холбоог үүсгэн байгууллаа.

Орон нутгийн Аялал Жуулчлалын үзэл баримтлал, алсын хараа

Хагас өдрийн турш болсон энэ сургалтанд нутгийн иргэд маш их идэвхтэй оролцсон нь (орон нутгийн Аялал жуулчлалын дэд зөвлөлийн гишүүд мөн оролцсон) тулгамдсан асуудлуудын нэг мөнөөс мөн гэдгийг батлагаажуулав. Аялал жуулчлалын үзэл баримтлал, алсын харааны талаар их идэвхтэйгээр ярилцсаны эцэст дараахь асуудлууд дээр санал нэгдэв:

Уламжлалт нүүдлийн соёлыг хадгалан хамгаалах арга замаар байгаль орчноо тогтвортой бөгөөд оновчтойгоор хамгаалах

ХНБЦГ үүд хот болох Хатгал Ханх хоёрт амьдрах орчныг сайжруулж, ажлын байр хангалттай бий болох

Байгаль орчинд ээлтэй, орон нутгийнхныг хүндэтгэдэг жуулчны урсгалыг бий болгох

Олон тооны биш чанартай жуулчин авах. Ингэснээр дараахь асуудлуудыг шийднэ:

- *Байгаль орчны даацын асуудал хөнгөрнө*
- *Жуулчдад үзүүлэх үйлчилгээ илүү хүртээмжтэй болно*
- *Дэд бүтцийн хэт хөгжил хумигдана*

Аялал жуулчлалын салбар болон орон нутгийн иргэдийн хоорондын уялдааг сайжруулах

Харин дээрх үр дүнд хүрэхийн тулд туйлын ойлгомжтой бөгөөд тодохрой Аялал Жуулчлалын Менежментийн төлөвлөгөө хэрэгтэй байна.

Ложистик

Сургалтын зохион байгуулалтын асуудлыг төслийн Хатгал дахь баг зохион байгуулсан бөгөөд ерөнхийдөө зохион байгуулалт сайн байсан хэдий ч дараагийн сургалтанд анхаарах зүйлсийг дор дурьдав.

Оролцогчдын тоо – урьдчилан тохирсноор нэг ангид 15-20 хүн байхаар төлөвлөгдсөн байсан боловч зарим нөхцөлд 40-өөд хүнтэй сургалтууд явагдсан. Ингэхлээр тараах материал дутан, хүн болгонд хүрч чадахгүй байв.

Анги/танхим – оролцогчдын тоотой харьцуулбал сургалтын танхимууд багтаамж муутай байсан бөгөөд төлөвлөж байсан бие даах буюу бусад практик дасгалуудыг хийхэд тохиромж муутай байлаа. Мөн цайны завсарлагааны үеээр хоорондоо ярилцаж, лавлагаа тодруулга хийх боломж байгаагүй. Магадгүй дараа дараагийн сургалтыг нутгийн гэр бааз, гэр буудлууд дээр хийвэл илүү зохимжтой болох байх.

Цагаа барих – бүх сургалтууд зарласан цагтаа эхлэх нь чухал тул үүнийг илүү сайн зохион байгуулах.

Дарагийн сургалт

Дараа дараагийн сургалтын хөтөлбөрийн хувьд чанарыг сайжруулж, өгөөжийг дээшлүүлхийн тулд тодорхой өөрчлөлтүүдийг санал болгов. Гэвч тэгэхийн тулд төслийн баг болон оролцогч нарын хооронд илүү сайн харилцаа холбоо хэрэгтэй болно:

- Суралцагчдын хувьд сургалтуудын талаар илүү ойлголттой байж, өөртөө хэрэгцээтэй сургалтаа эртхэн сонгох бөгөөд сургагч багш нарын хувьд суралцагч нарын мэдлэгийн түвшинд тааруулсан хөтөлбөрөөр хичээлээ заах боломжийг олгох.

- Хичээлийн хуваарийг ил тод зарлан, оролцогч нарт цагаа илүү оновчтойгоор төлөвлөх боломжийг олгох.

Нэмэлт өөрчлөлтүүд

- Аялал жуулчлалын бүтээгдхүүн бий болгох сургалтыг бүтэн өдөр болгох
- Хөтөч тайлбарлагч нарт зориулсан гүнзгийрүүлсэн сургалт явуулах
- “Аялал жуулчлалын үйлчилгээний харилцааны соёл, зочлох үйлчилгээ” болон “Жижиг бизнесийн удирдлага, санхүүжилт” сургалтыг нэгтгэн бүтэн өдрийн сургалт болгох
- Гар урлалын бүтээгдхүүн болон сав баглаа боодлыг нэг бүтэн өдрөөр хэвээр үлдээх
- Жуулчны урсгалын менежментийн хувьд тодорхой байршлууд дээр тусгайлан зөвлөгөө өгөх

Шинэ сургалтын санаанууд

- Хоол бэлтгэл, жуулчны хоолны нэр төрөл
- Биологийн төрөл зүйл, зэрлэг амьтан, шувуу таних аргачлал
- Биологийн төрөл зүйн судлагаа (ТХГН захиргаа, ажилтнууд)
- ТХГН дахь аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдхүүн (ТХГН захиргааны ажилтнууд)
- Хил дамнасан байгаль хамгаалах үйл ажиллагаа
- Байгаль хамгаалагч нарын солилцооны хөтөлбөр

Сургалт дууссаны дараа ХНБЦГ дарга Д. Батдэлгэртэй хийсэн уулзалтын үеээр авсан мэдээллээр тухайн газрын нийт ажилчдын 90% тус сургалтанд хамрагдсан гэсэн тоо гарсан бөгөөд бүгдээрээ сэтгэл хангалуун байсан байна. ТХГН удирдлага, аялал жуулчлалын дэд зөвлөлийн гишүүдийг гадаадын туршлага судлах аялалд хамруулах нь нэн чухал гэж үзэж байна.

Сургагч нарыг бэлдэх нь

Аялал жуулчлалын дэд зөвлөлийн гишүүдийн төлөөлөл тус сургалтанд хамрагдсан бөгөөд цаашдаа суралцах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн билээ. Сургагч багш нарын зүгээс эдгээр хүмүүстэй тусгайлан уулзаж, нарийвчилсан чиглэл гарган ажиллуулах нь зөв гэж үзэж байна.

3 Ханх дахь 2018 оны 1 сарын сургалтын хөтөлбөрийн санал

| | | |
|-----------------------|--|---|
| Өдөр 1 | Ханхруу аялах | Ё. Бадрал, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан, Лиза Чойгял |
| Өдөр 2 | | |
| Өдөр 3 0900 - 1600 | ТХГН дахь аялал жуулчлал, байгальд ээлтэй аяллын төрлүүд. Жуулчны урсгал, түүний менежмент-үндсэн зарчмууд хэрэгжилт | Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Лиза Чойгял |
| | Гар урлалын бүтээгдхүүний хөгжил, сав баглаа боодол зах зээлд нийлүүлэлт | Ё. Бадрал, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан |
| Өдөр 4 0900 - 1600 | Аялал жуулчлалын үйлчилгээний харилцааны соёл, зочлох үйлчилгээ | Ё. Бадрал, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан, Лиза Чойгял |
| | Аялал жуулчлалын бүтээгдхүүн бий болгох | Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Лиза Чойгял |
| Өдөр 5 | Хатгал явах | Ё. Бадрал, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан, Лиза Чойгял |
| Өдөр 6 0900 - 1500 | Хөтчийн тайлбарлах урлаг (гүнзгийрүүлсэн) | Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр |
| | Жижиг бизнесүүдийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх (урьдчилан цаг авах) | Ё. Бадрал, Б. Шатарсайхан, Лиза Чойгял |
| Өдөр 7 | Travel to UB | Ё. Бадрал, Д. Гэрэлтөв, Х. Түмэндэлгэр, Б. Шатарсайхан, Лиза Чойгял |



Хавсралт 1

Санал сэтгэгдэл, үнэлгээ

Сургалтын нэр: Аяллын хөтөч тайлбарлагчийн ур чадвар

Огноо: 2017.10.19

Хамрагдсан хүний тоо: 25

Сургалтын үнэлгээ:

| | Сургалтын агуулга | Сургалтын аргачлал | Ашиглагдсан жишээнүүд | Өөрт чинь хэр их нэмэртэй байсан | Багш нарын мэдлэг |
|-----------|-------------------|--------------------|-----------------------|----------------------------------|-------------------|
| Маш сайн | 18 | 17 | 17 | 19 | 22 |
| Сайн | 6 | 8 | 7 | 6 | 3 |
| Боломжийн | 1 | 0 | 1 | 0 | 0 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 22 | 0 | 3 |

Яагаад?

1. Хэрэгтэй мэдээлэлтэй
2. Хамрагдаагүй олон хүн байгаа.
3. Товч тодорхой ойлгомжтой байсан.
4. Ийм төрлийн сургалт хийгдэж байгаагүй учраас энэ зүйлүүдийг хүмүүст заавал хүргэх нь зайлшгүй
5. Өгөөжтэй
6. Нутгийн иргэд, малчдад
7. Ижил үйл ажиллагаа явуудаг хүмүүстээ
8. Маш гоё байлаа. Их зүйлийг мэдэж, санаа төрлөө.
9. Маш сайн сургалт болж байна.
10. Манай малчин иргэдийн амжиргааг дээшлүүлэх, тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэхэд иргэд идэвхитэй оролцож мэдлэгээ баяжуулахад орон нутгийн иргэдэд хандана.
11. Үр өгөөжтэй санагдсан. Мөн авах санаа их байна.

Нийт 25 хүний хариултыг шинжлэхэд 11 хүн сэтгэгдлээ бичиж 12 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө нь ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 10 | 14 | 1 |

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Ирж буй жуулчдын хоол хүнсний асуудлаар
2. Анхан шатны тусламж үзүүлэх сургалт
3. Анхан шатны сургалт
4. Дахин
5. Аялал жуулчлал, гэр буудлын зохион байгуулалт, зочдыг ямар хоол хүнсээр дайлж зочлох аргачлал, хоол хийх аргачлалаар сургалт явуулах
6. Анхан шатны эмнэлгийн тусламж
7. Хэлний сургалтанд хамрагдмаар байна.
8. Англи хэлийг хялбар, хурдан сурах сургалт
9. Сайн сургалтанд сууж баймаар байна.
10. Санхүү эдийн засаг
11. First Aid
12. Байгалийн аялал жуулчлал, ан амьтан судлах таних, аялал жуулчлалын талаар
13. Аялал жуулчлалын чиглэлээр
14. Тайлбарлах урлагийн талаар

Нийт 25 хүний хариулыг шинжлэхэд 14 хүн сэтгэгдлээ бичиж 11 хүн хоосон үлдээсэн байна.

Сургалтын нэр: Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, харилцааны соёл

Огноо: 2017.10.20

Хамрагдсан хүний тоо: 16

Сургалтын үнэлгээ:

| | Сургалтын агуулга | Сургалтын аргачлал | Ашиглагдсан жишээнүүд | Өөрт чинь хэр их нэмэртэй байсан | Багш нарын мэдлэг |
|-----------|---|--------------------|-----------------------|----------------------------------|-------------------|
| Маш сайн | 12 | 10 | 12 | 13 | 16 |
| Сайн | 4 | 6 | 4 | 3 | 0 |
| Боломжийн | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | Янз бүрийн сургалт явж байвал зүгээр байна. | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 15 | 1 | 0 |

Яагаад?

1. Аялал жуулчлал ихтэй хөгжиж байгаа тул Хатгалын ард иргэдэд хэрэгтэй.
2. Хэрэгтэй зүйл их байна.
3. Аялал жуулчлалын бүс нутагт амьдарч байгаа учраас өрхийн орлогоо дээшлүүлэх

Нийт 16 хүний хариултыг шинжлэхэд 3 хүн сэтгэгдлээ бичиж 13 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 10 | 6 | 0 |

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Хэлний сургалтанд хамрагдмаар байна
2. Тогооч, өглөөний цай
3. Хэлний сургалт, тогоочийн сургалт
4. First Aid
5. Хэлний сургалт, тогоочийн сургалт
6. АЖ-тай холбоотой наад захын ярианы дэвтэр хэрэгтэй байна. Англи хэлний сургалт хэрэгтэй байна.
7. Зөөгч, тогооч, хэлний сургалт, хоолны орц, өглөөний цай
8. Стандартын 00-ын талаар, халуун ус ванны талаар амар хялбар хийх тал дээр сургалт явуулах
9. Хоолны сургалт мөн хэлний сургалт хэрэгтэй байна.
10. Жуулчдад үйлчлэх хоолны зохион байгуулалт, өглөөний цай, үдийн цай, оройн хоолны порц зэргээр сургалт авмаар байна. Олон хүмүүс байна.
11. Хэлний, хөтөчийн, хоолны сургалтууд
12. Тогоочийн сургалт, өглөөний цайны сургалт, хэлний сургалт

Нийт 16 хүний хариултыг шинжлэхэд 12 нь сэтгэгдлээ бичиж 4 нь хоосон үлдээсэн байна.

Сургалтын нэр: ТХГН дахь аялал жуулчлал, байгальд ээлтэй аяллын төрлүүд

Огноо: 2017.10.18

Хамрагдсан хүний тоо: 34

Сургалтын үнэлгээ:

| | Сургалтын агуулга | Сургалтын аргачлал | Ашиглагдсан жишээнүүд | Өөрт чинь хэр их нэмэртэй байсан | Багш нарын мэдлэг |
|----------|-------------------|--------------------|-----------------------|----------------------------------|-------------------|
| Маш сайн | 19 | 18 | 18 | 18 | 28 |

| | | | | | |
|-----------|----|----|---|----|---|
| Сайн | 11 | 13 | 9 | 13 | 5 |
| Боломжийн | 4 | 3 | 7 | 3 | 1 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| | | |
|------|------|-----------|
| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
| 30 | 2 | 2 |

Яагаад?

1. Цэвэр усныхаа нөөцийг ариун цэвэр байлгах тал дээр иргэдэд санал тавина.
2. Чухал
3. Үр дүн ихтэй
4. Аялал жуулчлал эрхэлдэг гэр буудал, нутгийн иргэдэд тухайн чиглэлээр сургалт явуулах
5. Сурагчид, баазууд, гэр буудал, завьчид хөтөч нарыг
6. Нутгийн оршин суудаг иргэд, малчид
7. ТХГ-ын ХЗ болон АЖ эрхлэгчид хамтран уялдаатай ажиллах нь чухал
8. АЖ-ын чиглэлээр иргэдэд зөв аялах талаар мэдээлэл өгөх
9. Орон нутгийн захиргаа ХЗ-ны удирдлага, нутгийн иргэдэд АЖБ-ын удирдлага
10. Манай орон нутаг болоод бидний ажилд тулгардаг асуудлуудын талаар, түүний давж гарах арга замыг эрэлхийлсэн учраас
11. ОУ-ын туршлага жишигийг сайн мэддэггүй байлаа.
12. Бидэнд шаардлагатай байгаа тулгамдаж буй асуудлуудыг хөндөж буй учир
13. АЖ-ын үйл ажиллагаа эрхэлж буй бүх иргэн, аж ахуйн нэгжид
14. Хүнд хэрэгтэй, өөрийн болон орон нутагтаа сайнаар өгөөжтэй учир
15. АЖ хөгжиж байгаа бүс нутгийн иргэдэд
16. Орон нутгийн оршин суугчдад
17. Маш олон хүнд шаардлагатай
18. Тухайн хариуцсан нутаг дэвсгэрийн иргэдэд сургалт хүргүүлэх
19. Сэдэл өгөх
20. Маш олон хүнд хүргэх шаардлагатай
21. Өөрийн хариуцсан талбай дээрх айл өрхүүд бас хүмүүст сургалт маягаар зааж тайлбарлана.
22. Өөрийн хариуцсан газар, нутгийнхаа нутгийн иргэдэд өөрийн сурч мэдсэн бүхнээ ухуулан сургалт хийнэ.
23. Тус сургалтыг сумынхаа удирдлагуудад санал болгож нутгийнхаа үнэ цэнэтэй бүхнийг бусдад сурталчлах

Нийт 34 хүний хариултыг шинжлэхэд 23 хүн сэтгэгдлээ бичиж 11 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө нь ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| | | |
|------|------|-----------|
| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|

| | | |
|----|----|---|
| 13 | 19 | 2 |
|----|----|---|

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Гэр буудал
2. Хөвсгөл нуурын эко системд сөрөг нөлөөгүй эко 00 болон хог хаягдлын менежментийг яаж бий болгох талаар ойрын хугацаанд зөв шийдэл өгөх сургалт авмаар байна.
3. Сургалтуудыг ойр ойрхон хийж мэдлэг өгч байх
4. Холбоо, бүлэг болохын ач тусын талаар иргэдэд сургалт өгөх
5. Байгаль хамгаалагчийн мэдлэг дээшлүүлэх
6. Байгаль хамгаалагч, хөтөч нарт
7. Ирээдүйд чиглэсэн соён гэгээрүүлэх болон бусад улсын туршлагын талаар мэдээлэл хийсэн иймэрхүү сургалтыг нутгийн иргэдэд зориулж явуулах
 - Биологийн болоод хэлний чиглэлийн мэргэшүүлэх сургалтууд
8. Санхүүгийн ажилчин гэдгээрээ аливаа бүх сургалтаас хол байлгадаг. Биетээр туршлага судалж очиж үзмээр байна.
9. Шувуу таних, how to do guide!
10. Хөвсгөлийн БЦГ-т тохирох менежментийн талаар
11. Амьтны тухай /нэн ховор болон ховор/
12. Шинэ зөрчлийн тухай хуулийн талаар
13. Аялал жуулчлалын нутгийн эрэгтэй байгаль хамгаалагч нарт хамтран ажиллах сургалт хийх
14. Зөрчлийн тухай хуулиар судалгаа шинжилгээ, мониторинг
15. Хууль эрх зүй
16. АЖ-ын бүтээгдэхүүн олшруулах
 - ТХГ-ын мэргэжилтэн, БХ нарт зориулсан сургалт /тайлбар танилцуулга хийх гэх мэт/
 - Нутгийн иргэдэд энэ чиглэлийн сургалтыг өгмөөр байна.
17. Өшөө аялал жуулчлалын чиглэлээр ойр ойр сургалт авч баймаар байна.
18. Судалгаа шинжилгээний аргачлал, шинэ зөрчлийн тухай хуулийн талаар
19. Англи хэл хэр хурдан сурах талаар мэргэжлийн сургалт
20. Гадаад хэлний курст суралцах
 - Аяллын компанид дадлага хийх
21. Ер нь бол АЖ-ын суурь мэдлэгээ сайжруулмаар байна.

Нийт 34 хүний хариултыг шинжлэхэд 21 нь сэтгэгдлээ бичиж 13 нь хоосон үлдээсэн байна.

Сургалтын нэр: АЖ-ын бүтээгдэхүүн бий болгох нь

Огноо: 2017.10.18

Хамрагдсан хүний тоо: 19

Сургалтын үнэлгээ:

| | | | | | |
|--|-----------|-----------|-------------|-----------|------------|
| | Сургалтын | Сургалтын | Ашиглагдсан | Өөрт чинь | Багш нарын |
|--|-----------|-----------|-------------|-----------|------------|

| | агуулга | аргачлал | жишээнүүд | хэр их нэмэртэй байсан | мэдлэг |
|-----------|---------|----------|-----------|------------------------|--------|
| Маш сайн | 12 | 6 | 9 | 10 | 12 |
| Сайн | 7 | 10 | 3 | 6 | 7 |
| Боломжийн | 0 | 2 | 7 | 3 | 0 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 17 | 2 | 0 |

Яагаад?

1. Хүн бүрт хамаатай
2. АЖ эрхлэхэд хэрэгтэй байсан тул
3. АЖ эрхлэхээр бэлдэж байгаа хүмүүст бүгд хэрэгтэй зүйл байна.
4. Маш гоё байлаа. Дахиад л сонсоод баймаар, ярилцмаар байлаа.
5. Амьдралаа дээшлүүлэх янз бүрийн бизнест сонирхолтой хүмүүс их байгаа учраас
6. Тэр хүнд тус болохоор бол ярьж санаа бодлоо хэлнэ.

Нийт 19 хүний хариултыг шинжлэхэд 6 хүн сэтгэгдлээ бичиж 13 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө нь ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 8 | 9 | 2 |

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Бизнес эрхлэх сургалтанд хамрагдмаар байна.
2. Гар урлалын бүтээгдэхүүн хийх. Жишээ нь: Монгол хүүхэлдэй хийх
3. АЖ-ын менежментийн талаар
4. Дараа өдрүүдийн сургалтанд
5. Англи хэлний сургалтанд мэдлэгээ дээшлүүлэх
6. Англи хэлний хөнгөвчилсөн энгийн ярианы сургалтанд хамрагдмаар байна.
7. Жуулчдад сүү цагаан идээг ямар аргаар яаж борлуулах зүй зохистой амжиргааг яаж дээшлүүлэх боловсролоо дээшлүүлж сурч боловсрох сонирхолтой мэргэжилтэй болж ажил хийх хүсэлтэй байдаг.
8. АЖ-ын хөтөчийн морь унуулан хөтөч хийх
9. Гар урлал, сүлжмэл
10. Гар урлалын чиглэлээр

Нийт 19 хүний хариултыг шинжлэхэд 10 нь сэтгэгдлээ бичиж 9 нь хоосон үлдээсэн байна.

Сургалтын нэр: Орон нутгийн АЖ-ын үзэл баримтлал, алсын хараа

Огноо: 2017.10.18

Хамрагдсан хүний тоо: 16

Сургалтын үнэлгээ:

| | Сургалтын агуулга | Сургалтын аргачлал | Ашиглагдсан жишээнүүд | Өөрт чинь хэр их нэмэртэй байсан | Багш нарын мэдлэг |
|-----------|-------------------|--------------------|-----------------------|----------------------------------|-------------------|
| Маш сайн | 6 | 7 | 6 | 6 | 11 |
| Сайн | 10 | 9 | 10 | 9 | 5 |
| Боломжийн | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 11 | 0 | 5 |

Яагаад?

1. Олон хүн мэддэг болох хэрэгтэй.
2. Яагаад гэвэл энэ сургалт бидэнд ч илүү хувь нэмэртэй байсан шиг бусдад ч хэрэгтэй, мэдлэг болох учраас
3. Илүү олон хүнд хүргэх нь чухал
4. Мэдэхгүй. Учир нь олон төрөл хэлбэрийн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийн ойлгох нөхцөл байдал өөр
5. Маш хэрэгтэй юм байна.
6. Үр дүнтэй байгаа учир

Нийт 16 хүний хариултыг шинжлэхэд 6 хүн сэтгэгдлээ бичиж 13 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө нь ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 8 | 7 | 1 |

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Гар урлалын, арьсан эдлэл
2. Хог хаягдал, 00-ын асуудлын талаар сургалтанд хамрагдмаар байна.

3. Жуулчдад үйлчлэх худалдаа нийтийн хоол, зочид буудлын үйлчилгээний талаар
4. Төрөлжсөн сургалтууд хийх, гар урлал, хөтөч, зочлох үйлчилгээ гэх мэт
5. Хэлийг хэрхэн хялбар сурах вэ?
6. Эко АЖ-ыг хэрхэн бий болгох

Нийт 16 хүний хариултыг шинжлэхэд 6 нь сэтгэгдлээ бичиж 10 нь хоосон үлдээсэн байна.

Сургалтын нэр: Жижиг дунд бизнесийн удирдлага, санхүүжилт

Огноо: 2017.10.20

Хамрагдсан хүний тоо: 11+12/хоосон цаас/ =23

Сургалтын үнэлгээ:

| | Сургалтын агуулга | Сургалтын аргачлал | Ашиглагдсан жишээнүүд | Өөрт чинь хэр их нэмэртэй байсан | Багш нарын мэдлэг |
|-----------|-------------------|--------------------|-----------------------|----------------------------------|-------------------|
| Маш сайн | 8 | 6 | 9 | 10 | 11 |
| Сайн | 3 | 5 | 2 | 1 | 0 |
| Боломжийн | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 8 | 1 | 2 |

Яагаад?

1. АЖ хөгжиж байгаа Хатгалын иргэдэд маш чухал хэрэгтэй сургалт байна.
2. Маш их хэрэгтэй мэдээллийг авсан.
3. Олон хүн сонсох тусам АЖ-ын мэдлэгтэй болно.
4. Туршлага олгох
5. Аяллын зарчим шинэ санаанууд их олон байгаа учраас

Нийт 11 хүний хариултыг шинжлэхэд 5 хүн сэтгэгдлээ бичиж 6 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө нь ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 5 | 4 | 2 |

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Гар урлал, эко, байгалийн бүтээгдэхүүн хийж сурах

2. Эвэр, ясан урлал, сийлбэр
3. Гэр буудлын статистикийн талаар сургалт хэрэгтэй байна. Гэр буудлын төсөл бичиж сурах
4. Жуулчдын хоол үйлдвэрлэлийн талаар, технологи цагаан хоолны төрлөөр сургалт явуулах
5. Public organization's approach
6. Эсгий урлал
7. Төрөлжсөн аяллуудыг яаж зохион байгуулдаг талаар

Нийт 11 хүний хариултыг шинжлэхэд 7 нь сэтгэгдлээ бичиж 4 нь хоосон үлдээсэн байна.

Сургалтын нэр: Гар урлал, бэлэг дурсгал, сав баглаа боодол

Огноо: 2017.10.21

Хамрагдсан хүний тоо: 47

Сургалтын үнэлгээ:

| | Сургалтын агуулга | Сургалтын аргачлал | Ашиглагдсан жишээнүүд | Өөрт чинь хэр их нэмэртэй байсан | Багш нарын мэдлэг |
|-----------|-------------------|--------------------|-----------------------|----------------------------------|-------------------|
| Маш сайн | 31 | 24 | 26 | 29 | 33 |
| Сайн | 14 | 18 | 13 | 12 | 11 |
| Боломжийн | 1 | 4 | 7 | 5 | 2 |
| Муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Маш муу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлбар | | | | | |

Тус сургалтыг өөр хүнд санал болгох уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 35 | 6 | 5 |

Яагаад?

1. Маш чухал тул амьдралд хэрэгтэй.
2. Ренчинлхүмбэ сумынхаа гар урлал, жижиг бизнес эрхэлдэг хүмүүст сав баглаа боодол, сургалт явахаар сумынхаа иргэдэд санал болгож байна.
3. Шинэ санаанууд авах
4. Мэдээ мэдээлэл авах хэрэгтэй
5. Хүнд хэрэгтэй, цаг үеэ олсон, чанартай сургалт байна.
6. Өөр залуучуудад хэлж ярьж өгнө.
7. Багш нарын заах ур чадвар боломжийн байсан тул өөр хүнд санал болгохгүй.
8. Хамт ажиллах хүндээ өөрөө сурсан зүйлээ сайн хэлж өгнө.
9. Маш сайн сургалт чанартай учир бид бүгдэд, амьдралд ашигтай.
10. Маш өгөөжтэй сургалт байна. Санаа авах зүйл их байлаа.
11. Суугаагүй таньдаг гар урлалын хүмүүс маш их байгаа тул тэд нарт хэлнэ.

12. Шинэ санаанууд, боломжийн.
13. Хүнд ахуй амьдралд хэрэгтэй.
14. Манай нөхөрлөлийн гишүүдэд маш их ач холбогдолтой сургалтууд байлаа. Нийт багш нартаа болон зохион байгуулсан бүх хүмүүстээ талархлаа.
15. Янз бүрийн сургалт хийж байх нь зөв зүйтэй юм байна.

Нийт 46 хүний хариултыг шинжлэхэд 15 хүн сэтгэгдлээ бичиж 31 хүн хоосон үлдээсэн байна.

Өмнө нь ийм чиглэлийн сургалтанд сууж байсан уу?

| Тийм | Үгүй | Бөглөөгүй |
|------|------|-----------|
| 22 | 20 | 4 |

Өөр ямар чиглэлийн сургалтанд хамрагдмаар байна. Тодорхой бичнэ үү.

1. Гар урлал төрөл, керамик, арьс дээр зурах
2. Англи хэлийг хэр хурдан ямар аргаар сурах талаар сургалт авах
3. Оёдол эсгүүрийн
4. Эсгий урлал, шүрэн урлалын сургалтыг явуулах.
5. Гар доорх материалыг ашиглан
6. Гар урлалын. Жишээ нь: Эвэр, ясан урлал, сийлбэрийн сургалт хэрэгтэй байна.
7. Каллиграф бичгийн сургалт, зургийн сургалт байвал сайн байна.
8. Эсгий, арьсан эдлэлийн сургалтанд хамрагдмаар байна.
9. Жуулчны баазуудын эрх бүхий хүмүүстэй гар урлал эрхлэгч иргэдийг уулзуулах уулзалт зохион байгуулж харилцан санал солилцон гар урлалыг баазуудаар борлуулдаг болгоход туслалцаа үзүүлэх уулзалт зохион байгуулахад дэмжлэг.
10. Сийлбэр, уран зургийг олон чиглэлээр бодит байдалд үндэслэн сургалтанд
11. Санхүү эдийн засаг бизнесийн сургалтанд хамрагдмаар байна.
12. Хайчилбар /төрөл бүрийн/
13. Гар урлал, дээл
14. Нэхмэл, хатгамал мөн мах махан бүтээгэхүүн боловсруулах сургалт хэрэгтэй байна.
15. Хүнс, эсгүүр
16. Хүнсний сав баглаа болон боодол, хүнсний бүтээгдэхүүний стандарт гэх мэт талын сургалт хэрэгтэй байна.
17. Хулдаасан бар, модон барны сургалт явуулмаар байна. Мөн гар урлал, модоор сийлбэр сургалт явуулбал их хэрэгтэй байна.
18. Сургалт олон төрлөөр байвал сайн байна. Баярлалаа.
19. Бэлэг дурсгалын зүйл хийх. Жишээ нь: Түлхүүрийн оосор, арьсан цүнх хийх.
20. Янз бүрийн сургалт явуулах хэрэгтэй байна.
21. Гар урлал
22. Эсгий хийх, оёдол эсгүүр, сүү сүүн бүтээгдэхүүн
23. Гар урлал, өөр янз бүрийн сургалт явуулбал хэрэгтэй байна.
24. Керамик урлалын сургалт
25. Гар урлал бас өөр янз бүрийн сургалт байвал хэрэгтэй байна.

26. Цаашид модон бар болон хулдаасан барын сургалт нөхөлөлийн гишүүддээ авмаар байна. Мөн хөтөчийн, хэлний сургалтыг онлайнаар авахыг хүсч байна. /Төлбөрөө төлөөд/
27. Хоол амтлагч, ногоог тасалгаанд ургуулах тухай. Бизнес төлөвлөх, санхүүгээ зохицуулах тухай гүнзгийрүүлж үзэх.

Нийт 11 хүний хариултыг шинжлэхэд 7 нь сэтгэгдлээ бичиж 4 нь хоосон үлдээсэн байна.

Хавсралт 2

Ёс зүйн дүрмүүд

NIUE TOURISM BUSINESS

Code of Practice

As consumers become more sophisticated, and the natural values of a destination are recognised, it is increasingly important to be able to demonstrate a commitment to sustainable development and encourage continuous improvement from the tourism industry and more responsible behaviours and actions by visitors.

THE PRINCIPLES

- Quality in tourism service delivery
- Proficient in tourism business
- Effective communication with customers
- Commitment to staff training
- Respect for cultural difference
- Attention to safety and security
- High standards of cleanliness and hygiene
- Care for the local ecosystem
- Reduction of waste and pollution
- Support for the local community
- Implementation and use of the code

ACTIONS

SERVICE AND PROFESSIONALISM

- Marketing and promotional materials are accurate and truthful in the nature, price and quality of the service provided
- Every effort is made to ensure guests' expectations are met in the provision of service and facilities
- The business complies with all relevant laws of Niue
- The business must not allow or accommodate any form of discrimination (racial, religious, gender, disability)
- Staff are given required training and instruction in their area of work, personal hygiene and grooming and environment and cultural policies
- Procedures for the prompt handling of complaints are in place, and inquiries and refunds are dealt with properly and consistently

SAFETY & CARE

- Staff and management are trained and equipped to deal with all emergencies and emergency procedures are clearly displayed
- Cleanliness and hygiene are observed in all areas of the business operations
- Considerable care is taken in the operation and maintenance of facilities to ensure a safe environment for guests and staff at all times
- All customers and staff are treated with equal respect and consideration

SUSTAINABILITY

- Tourism activities are compatible with the local ecosystem, cultural heritage and traditions
- Tourism business is respectful of local cultural protocol and tourists are well informed about local customs, values and appropriate dress code and conduct
- Tourism business works closely with the local community and uses local labour, goods and service whenever possible



www.niueisland.com

NIUE VISITOR CODE OF CONDUCT

golden rules for your stay in Niue

With your help we can ensure Niue continues to be a great place for everyone to enjoy.

During your stay we ask that you:

- Treat all people with respect and politeness.
- Respect cultural and religious protocols and beliefs and act in a manner consistent with Niuean philosophy.
- Appreciate that not everything in Niue will be the same as in your own country.
- Respect Niue, its environment and facilities.
- Contribute to Niue's commitment to responsible tourism through appropriate waste management, energy and water conservation.



Fakaane, thank you



www.niueisland.com



AUSTRALIA

Suite 5, 3/4 Gippsland Street
PO Box 837, Jindabyne NSW 2627

Phone: +61 2 64562722

Email: enquiries@trctourism.com

NEW ZEALAND

Level 5, EMC Building, 5-7 Willeston Street
PO Box 2515, Wellington 6140

Phone : +64 4 4723114

Email: info@trctourism.com

www.trctourism.com



INSPIRING SOLUTIONS
FOR PEOPLE AND PLACES